

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ 2 ДУГААР ХУРАЛДААНЫ ТОЙМ

Төрийн албаны зөвлөлийн батлан хамгаалах яамны дэргэдэх салбар зөвлөлийн 2021 оны 02 дугаар хуралдааныг 01 дүгээр сарын 26-ны өдөр Батлан хамгаалахын сайдын хуралдааны танхимд зохион байгуулж, 3 асуудал хэлэлцэн шийдвэрлэв.

1. Ахмад цолыг - 1, дэслэгч цолыг - 1, дэд ахлагч цолыг - 1 нийт 3 офицер, ахлагчид албан тушаалын зэрэглэлийн цэргийн цол олгуулах санал хүргүүлхээр хэлэлцэн батлав.

2. Мөн хуралдаанаар Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Орон нутгийн хамгаалалт, улсын дайчилгааны хэлтсийн даргаар Зэвсэгт хүчний Жанжин штабын Бодлого, стратегийн төлөвлөлтийн газрын Стратегийн төлөвлөлтийн хэлтсийн Стратегийн удирдлага, төлөвлөлтийн ахлах мэргэжилтэн Рэнцэн овогтой хурандаа Энхболд;

- Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргаар Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн Албаны дарга, хангалтын офицер Мөрдорж овогтой хошууч Амартүвшин нарыг тус тус томилов.

3. Монгол Улс анхдугаар Үндсэн хуулиа баталж Бүгд Найхамдах улс тунхагласаны 96 жилийн баярыг тохиолдуулан Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, харьяа анги, байгууллагын албан хаагч, ахмад настнуудаас

- Хөдөлмөрийн баатар;
- Монгол Улсын ардын жүжигчин
- Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат ажилтан
- Монгол Улсын гавьяат нисгэгч
- Монгол Улсын гавьяат холбоочин
- Монгол Улсын хүний гавьяат эмч
- Монгол Улсын гавьяат хуульч
- Монгол Улсын гавьяат эдийн засагч
- Монгол Улсын гавьяат тээвэрчин
- Монгол Улсын гавьяат тамирчин
- Монгол Улсын үйлчилгээний гавьяат ажилтан
- Монгол Улсын гавьяат багш
- Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн
- Монгол Улсын гавьяат жүжигчин
- Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн
- Чингис хааны одон
- Сүхбаатарын одон
- Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон
- Алтан гадас одон
- Цэргийн гавьяаны улаан тугийн одон
- Цэргийн гавьяаны одон
- Хөдөлмөрийн хүндэт медаль
- Цэргийн хүндэт медаль
- Батлан хамгаалах яамны хүндэт тэмдэг
- Батлан хамгаалахын тэргүүний ажилтан
- Батлан хамгаалах яамны Жуух бичиг

- Дайчин алдар I медаль
- Дайчин алдар II медаль
- Дайчин алдар III медаль
- Ахмад дайчин медаль
- Эх орны төлөө I хүндэт тэмдэг
- Эх орны төлөө II хүндэт тэмдэг
- Эх орны төлөө III хүндэт тэмдгээр нийт 1586 офицер, ахлагч, ажилтан албан хаагч, ахмад настны нэр санлыг тус тус шагнуулахаар шийдвэрлэсэн.